



138

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2006 оны 4 сарын 25 өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

### Нийслэлийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төвийг байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 10.1.4, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрмийн 2.6 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ Нь:

Нэг. Нийслэлд Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төвийг Багануур дахь Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын төсөв, санхүү, орон тоо, үндсэн ба эргэлтийн хөрөнгөнд түшиглэн 2006 оны 05 дугаар сарын 01-нээс эхлэн байгуулан ажиллуулсугай.

Хоёр. Багануур дүүрэг дэх Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрыг 2006 оны 05 дугаар сарын 01-нээс эхлэн Нийслэлийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төв болгон Сонгинохайрхан Эрүүл мэндийн нэгдлийн салбар амбулатори № 2-ын II корпуст шилжүүлэн байрлуулсугай.

Гурав. Багануур дүүрэг дэх Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын байрлаж байсан барилгыг тус дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн мэдэлд, бусад үндсэн ба эргэлтийн хөрөнгийг Нийслэлийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төвийн эзэмшилд балансаас балансад тус тус шилжүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Ц.Ганхүү/-т тус тус зөвшөөрсүгэй.

Дөрөв. Нийслэлийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төвийн бүтэц, орон тоо, цалингийн санг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Тав. Нийслэлийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төвийг Эрүүл мэндийн салбарын төсвийн багцаас зохих журмын дагуу санхүүжилт хийхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/-т даалгасугай.

Зургаа. Багануур дүүрэг дэх Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газарт ажиллаж байсан хүмүүсийн ажлыг хууль зүйд нийцүүлэн зохицуулж, Нийслэлийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төвийн дүрмийг шинэчлэн батлан мөрдүүлэхийг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Ц.Ганхүү/-т даалгасугай.

Долоо. Нийслэлийн Засаг даргын 2000 оны 250 дугаар захирамжийн 9 дүгээр заалт болон Багануур дүүргийн Засаг даргын 2005 оны 72 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР

№. фол. Зак-04  
0200729